

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Соёл, урлагийн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/139/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Алтай хот
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа
Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Цэрэнханд
Утас: 99086371 Цахим хаяг: tserenkhandd@audit.gov.mn
Аудитор: Б.Батбаатар
Утас: 89593311 Цахим хаяг: batbaatarb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.19 № 37

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Соёл, урлагийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймгийн Соёл, урлагийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Монгол Улсын яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэлд багтсан Монгол Жангар хайлах өвийг сэргээх, хадгалан, хамгаалах, өвлүүлэн үлдээх зорилгоор "Туульсын хаан Жангар" арга хэмжээг Алтай хотод зохион байгуулсан байна.

Аудитын гол асуудал

Улсын төсвөөс олгосон санхүүжилт өмнөх оноос 97,355.7 мянган төгрөгөөр өссөн нь төрийн албан хаагчдын цалин, хөлс нэмэгдсэнтэй холбоотой байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант онд 3 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 47 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, 94.0 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

07.02.20

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Г.ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мян.төгрөгөөр/

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	10,869.6	7,309.7
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	35,443.7	37,533.7
Нийт хөрөнгийн дүн	46,313.3	44,843.4
Нийт өр төлбөрийн дүн	18.1	0.0
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	46,295.1	44,843.4
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	46,313.3	44,843.4
Үйл ажиллагааны орлогын дүн	268,486.6	652,476.6
Үйл ажиллагааны зардлын дүн	234,427.9	653,928.3
Үйл ажиллагааны үр дүн	34,058.6	(1,451.7)
Үйл ажиллагааны бус үр дүн	0.0	0.0
Үйл ажиллагааны нийт үр дүн	34,058.6	(1,451.7)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	14,018.9	46,295.1
Тайлант оны үр дүн	32,276.2	(1,451.7)
Эцсийн үлдэгдэл	46,295.1	44,843.4
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	25,8302.7	647,620.2
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	230,822.2	641,317.2
Үйл ажиллагааны ЦМГ	27,480.5	6,303.0
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(27,480.5)	(6,303.0)
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	0.0	0.0
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0.0	0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	3,386.0	300,917.2
Урсгал зардал	380.0	300,917.2
Төвлөрүүлэх шилжүүлэг	3,006.0	0.0
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	212,133.9	309,489.6
Улсын төсвөөс санхүүжих	212,133.9	309,489.6
Орон нутгийн төсвөөс санхүүжих		309,489.6

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1.0 сая төгрөгийн 5 зөрчил¹ илэрснээс, 0.5 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 0.5 сая төгрөгийн 2 зөрчил арилгах албан шаардлага, 1 хариуцлага тооцох албан шаардлага, 2 зөвлөмж өгсөн.

4.4.2 Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт

Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөр 7.9 сая төгрөгийг татварын нэвтрэлтийн нэгдсэн системд дутуу шивсэн байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа үйлчилгээний төлбөрийн баримтын нөхөн шивэх албан шаардлага хүргүүлсэн.

5.1 Төлбөрийн акт

1. Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөр 5.0 сая төгрөгөөс татвар 0.5 сая төгрөгийг суутгаагүй байгаа нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.Энэ хуулийн дараах зүйл, хэсэг, заалтад дурдсан орлогод доор дурдсан хувиар тооцож, албан татвар ногдуулна: 21.2.4.энэ хуулийн 15.1, 16 дугаар зүйл, 17.1.2, 17.1.3-т зааснаар тодорхойлсон орлогын дүнд 10 хувиар тооцож албан татвар ногдуулна гэж заасантай тус тус нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн нь: Хувь хүний орлогын албан татварын орлогыг суутгаж орон нутгийн төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Зардлын эдийн засгийн ангилал зөрчин бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас утас, гэрэл, цом зэрэг 0.5 сая төгрөгийн гүйлгээ хийсэн нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын холбогдох заалтуудыг бичих гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг ангиллын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлсэн.

2. Эд хариуцагчийн дансаар 211.8 сая төгрөгийг шилжүүлэн авч зарцуулсан боловч кассын тайлан гаргаагүй, тооцоо бодоогүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно", Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын хавсралтын 2 дугаар зүйлийн 2.7-т "Мөнгөн кассын санхүүгийн баримт нь засваргүй, үнэн зөв хөтлөгдөж, баримтын бүрдлийг хангасан байх ба зарлагын төлбөр гүйцэтгэх орхийг олгохон албан ёоны шийдвэрт үндэслэгдөн цохолт

хийгдсэн байна", гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн албан тушаалтан хариуцлага тооцох албан шаардлагыг хүргүүлсэн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн аудиттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Гаднын машинаар үйлчилгээ үзүүлэхдээ спидометрийн заалтыг үндэслэн тооцоогүй бодоогүй, байгуулсан гэрээг дүгнээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"-тай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шатахууны тооцоог спидометрийн заалт бичсэн, анхан шатны баримтын бүрдэл хангасан баримтаар хийж байх

2. Цалингийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Ур чадварын нэмэгдлийг шалгуурын дагуу дүгнээгүй 4.9 сая төгрөгийг олгосон нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тушаал "төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам", Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, сангийн сайдын хамтарсан 1996 оны 04 сарын 20-ны өдрийн 63/104 дүгээр тушаал "Төрийн үйлчилгээний албаны түгээмэл мэргэжлийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох журам"-ын 5-д "ажилтанд олгож байгаа ур чадварын нэмэгдлийг заасан хязгаарт багтаан нэмэгдүүлэх, бууруулах асуудлыг улирал бүр хэлэлцэн шийдвэрлэж байна", 7-д "Ур чадварын нэмэгдлийг ажилтнуудын цалинг нэмэх, амьдрал ахуйг харгалзах зэргээр хавтгайруулан олгохыг хориглоно."-тай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ур чадварыг нэмэгдлийг олгохдоо улирал бүр шалгуурын дагуу дүгнэж олгох

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл												
Байгууллагын нэр	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/									
			Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн

Говь-Алтай аймгийн Соёл, урлагийн газар	5	1.0	1	0.5	1	0.5	2	-	1	-	-	-
Дүн	5	1.0	1	0.5	1	0.5	2	-	1	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал								
Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/					
			Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Говь-Алтай аймгийн Соёл, урлагийн газар	1	7.9	-	-	1	7.9	-	-
-Нийт дүн	1	7.9	-	-	1	7.9	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			